МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр Дугаар А/580 Алтай хот

Монгол Улсын Ерөнхий сайдын
айлчлалын тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын бэлтгэл хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2020 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх болон холбогдох албаны хүмүүс тус аймагт ажилласантай холбоотойгоор зохион байгуулсан хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулагдах 5141500 (таван сая нэг зуун дөчин нэгэн мянга таван зуун) төгрөгийг Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Баттайван)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАНБАТ

C:/My Documents/ZAHNR-3A-4.doc

0201001525